

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН  
2022 ОНЫ 04 ДҮГЭЭР ХУРАЛДААН**

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 04 дүгээр хуралдааныг 15 цаг 00 минутад Нутгийн удирдлагын ордны II давхрын хурлын танхимд хийж, Зөвлөлийн гишүүдийн 100 хувийн ирцтэй хуралдав.

Д/д	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Аймгийн төвийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа, хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнг хэлэлцүүлэх тухай	<p><b>ШИЙДВЭРЛЭСЭН нь:</b></p> <p>1. Аймгийн Засаг даргын 2021 оны А/432 дугаар захирамжаар байгуулсан “Аймгийн төвийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт өгөх” ажлын хэсэг Жаргалант сумын ерөнхий боловсролын 8 сургуулийн үйл ажиллагааг үнэлж, дүгнэсэн “Байгууллагын менежмент, удирдлагын манлайлал”, “Хүний нөөцийн менежмент”, “Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн”, “Сургалтын орчин, үйлчилгээг ээлтэй байлгах, эцэг эх, олон нийтийн оролцоо, түншлэл” гэсэн 5 үзүүлэлт тус бүрээр үнэлгээ, дүгнэлтээ нарийвчлан гаргаж, сургууль тус бүрд хүргүүлэн, хамт олны хурлаар үнэлгээний дүнг танилцуулах;</p> <p>2. Жаргалант сумын ерөнхий боловсролын 8 сургуулийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнг ажлын хэсэг дахин нягтлан хянаж, Боловсрол, шинжлэх ухааны газрын мэргэжилтний зөвлөлөөр хэлэлцүүлэн албажуулж, хангалтгүй үнэлгээтэй дүгнэгдсэн сургуулийн захирал, сургалтын менежер нарт хариуцлага тооцуулах саналаа Жаргалант сумын Засаг даргад хүргүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга Б.Алтангэрэлд үүрэг болгов.</p>
2	Сум, байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнг хэлэлцүүлэх тухай	<p><b>ШИЙДВЭРЛЭСЭН нь:</b></p> <p>1. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын 2021 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгээр 95-дээш хувьтай үнэлэгдсэн Эрүүл мэндийн газар (Зоонозын өвчин судлалын албатай), Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Стандарт, хэмжил зүйн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Зэвсэгт хүчний 123 дугаар анги, Ус цаг уур орчны шинжилгээний төв, Онцгой байдлын газрыг тус тус шилдэг байгууллагаар шалгаруулсан;</p> <p>2. Сумдын 2021 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгээр өндөр үнэлгээ авч бусдыгаа манлайлсан Эрдэнэбүрэн сумыг 1 дүгээр байр, Цэцэг сумыг 2 дугаар байр, Жаргалант, Манхан сумдыг 3 дугаар байр, Мянгад сумдыг 4 дүгээр байр эзлүүлсэн;</p>

		3. Багуудын 2021 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгээр өндөр үнэлгээ авч бусдыгаа манлайлсан Булган сумын Баянгол, Дуут сумын Хөхбэлчир, Жаргалант сумын Алагтолгой, Бугат, Манхан сумын Төгрөг гол, Мөнххайрхан сумын Борт, Мянгад сумын Чацаргант, Ховд сумын Дунд-Ус багуудыг 2021 оны шилдэг багаар тус тус шалгаруулан, урамшуулах захирамжийн төсөл боловсруулж танилцуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга Д.Ариунбилэгт үүрэг болгов.
3	Орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжих Орон нутгийн сангийн журам батлах тухай	ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Аймгийн “Шинэ Ховдын хөгжил” сангийн журмыг хэлэлцэх явцад Зөвлөлийн гишүүдээс гарсан санал, зөвлөмжийг тусгаж, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжлан шийдвэрлүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ч.Багдалд үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР